

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС
ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ
БАТЛАН ГАРГАХАД ЗОРИУЛСАН

ГАРЫН АВЛАГА



2020

— УЛААНБААТАР ХОТ —

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС
ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ
БАТЛАН ГАРГАХАД ЗОРИУЛСАН

ГАРЫН АВЛАГА



2020

— УЛААНБААТАР ХОТ —

Энэхүү гарын авлагыг Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд дэд профессор, доктор Д.Сүнжидийн боловсруулсан эхэд үндэслэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын ажлын хэсэг боловсруулав.

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ БАТЛАН ГАРГАХАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Гарын авлагыг бэлтгэсэн:

Р.Тунгалаг-Эрдэнэ	Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
М.Батдорж	Архангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
Б.Галхүү	Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
Т.Гончигдорж	Өвөрхангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
Т.Эрдэнэбат	Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Хянан тохиолдуулсан:

Д.Сүнжид	Дэд профессор, доктор, судлаач
Э.Сэлэнгэ	Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтсийн ахлах шинжээч

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	4
Нэг. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ.....	5
1.1. Захиргааны хэм хэмжээний актын тодорхойлолт, үндсэн шинж	6
1.2. Захиргааны шийдвэрийн хэлбэр, тэдгээрийн адил ба ялгаатай шинж.....	8
Хоёр. ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ.....	11
2.1. Бэлтгэл үе шат.....	12
2.2. Хянан бүртгэх үе шат.....	20
2.3. Захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр болох:.....	23
Гурав. БУСАД.....	24
3.1. Захиргааны хэм хэмжээний актад нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох:.....	24
3.2. Хяналт- шинжилгээ, үнэлгээ.....	24
3.3. Тусгай зохицуулалт.....	25
Дөрөв. ХАВСРАЛТ.....	26
4.1. ИТХ-аас захиргааны хэм хэмжээний актын төслийг шалгах хяналтын хуудас.....	26
4.2. Батлагдсаны дараах хяналтын хуудас.....	29
4.3. Хэлэлцүүлгийн тэмдэглэлд хавсаргах хүснэгтийн загвар.....	29
4.4. Жишээ.....	30

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗЕХ.....Захиргааны ерөнхий хууль

ЗЗНДНТУТХ.....Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж
түүний удирдлагын тухай хууль

ИТХ.....Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

ХЗДХЯ.....Хууль зүй, дотоод хэргийн яам

Нэг. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг байгууллагуудаас захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлсэн Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлд нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхээр заасан тул ЗЕХ-ийн үйлчлэлийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр хамаарч байна.


ЗЕХ-ийн дагуу захиргааны шийдвэр батлан гаргахад түүний хэрэгцээ шаардлагыг нотлох үр нөлөөний үнэлгээ хийж байх, цар хүрээ, эрх ашиг сонирхол нь хөндөгдөж болох бүлгийг урьдчилан тодорхойлох, хэрэгжүүлэхэд шаардагдах эдийн засаг, хүний нөөцийн тооцооллыг гаргах, шийдвэрийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, төрийн төв байгууллагад бүртгүүлэх, хэрэгжилтэд нь жил бүр хяналт үнэлгээ хийж, үр дүнг тайлагнаж байх шаардлагууд нэмэгдсэн.

**Захиргааны хэм хэмжээний акт дараах
арван шаардлагыг хангасан байна.
/ЗЕХ 60.1.1/**


- Монгол Улсын Үндсэн хууль, ЗЕХ болон бусад хуульд нийцсэн байх;
- тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх;
- тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заасан байх;
- шийдвэрийн заалт хоорондоо болон эрх бүхий бусад этгээдийн гаргасан шийдвэрийн заалттай зөрчилдөхгүй байх;
- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх;
- хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх;
- тухайн шийдвэрээр урьд нь гарсан шийдвэрийг хүчингүй болсонд тооцож байгаа, эсхүл түүнд өөрчлөлт оруулж байгаа бол энэ тухай заалтыг тусгасан байх;
- бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх;
- баталсан байгууллага, албан тушаалтны болон захиргааны хэм хэмжээний актын нэр, он, сар, өдөр, дугаарыг тодорхой заасан байх;
- хуульд заасан бусад шаардлага.

1.1. ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТОДОРХОЙЛОЛТ, ҮНДСЭН ШИНЖ

Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг хэлнэ. /ЗЕХ 59.1/



Захиргааны хэм хэмжээний акт нь дүрэм, журам, зааварчилгаа, загвар, маягт, аргачлал, төлөвлөгөө зэрэг олон нэршилтэй байдаг. Тухайлбал, “Нийслэлийн нутаг дэвсгэр дээр гадна сурталчилгаа байрлуулах тухай” нийслэлийн ИТХ-ын тогтоолоор баталсан журам, “Байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Сэлэнгэ аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан журам, гэх мэт.



Захиргааны хэм хэмжээний актыг гаргаж буй субъект нь захиргааны байгууллага байгаад зогсохгүй уг захиргааны байгууллагад “хуулиар тусгайлан эрх олгосон” байхыг шаарддаг. **ЗЗНДНТУТХ-ийн 18, 19 дүгээр зүйлээр ИТХ-д олгосон бүх бүрэн эрхийг ИТХ-ын Тэргүүлэгчид хэрэгжүүлэх эрх олгогдоогүй.**



Тайлбар: ЗЗНДНТУТХ-ийн 20.1.7-д хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрх ИТХ-ын Тэргүүлэгчдэд хадгалагдаж, хэрэгжүүлэхээр заажээ. Энэхүү заалт нь ЗЕХ-д заасан **“хуулиар олгогдсон тусгайлан эрх”** болох эсэхийг тогтоохын тулд ИТХ ба ИТХ-ын Тэргүүлэгчдийн эрх хэмжээг ялгамжтай авч үзэх шаардлагатай.

Хэдийгээр ЗЗНДНТУТХ-ийн 9.2-т зааснаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны чөлөө цагт бүрэн эрхийг нь тэдгээрийн Тэргүүлэгчид хэрэгжүүлнэ гэж заасан боловч ЗЗНДНТУТХ -ийн 20.1-д заасан Хурлын тэргүүлэгчдийн бүрэн эрхэд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчид энэ хуулийн 18.1.1.“е”, 18.1.1.“ж”, 18.1.2.“г”, 18.1.2.“ж”, 18.1.2.“з”, 18.1.3.“в”, 18.1.3.“г”, 18.1.3.“ж”, 18.1.3.“з”, 18.1.3.“к”, 18.1.3.“л”, 18.1.3.“н”-д заасан Хурлын бүрэн эрхийг Хуралд дараа тайлагнахаар Хурлын чөлөө цагт хэрэгжүүлж болохоос гадна дараахь асуудлыг өөрийн бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ” хэмээн нарийвчилж заасан бөгөөд тодорхой 12 заалтаар энэхүү бүрэн эрхийг тодорхойлжээ.

Тиймээс ЗЗНДНТУТХ-ийн 9.2 дахь заалт ерөнхий заалт, харин ЗЗНДНТУТХ-ийн 20.1 дэх заалт нь нарийвчилсан заалт, өөрөөр хэлбэл ЗЗНДНТУТХ-ийн 18, 19 дүгээр зүйлээр ИТХ-д олгосон бүх бүрэн эрхийг ИТХ-ын Тэргүүлэгчид хэрэгжүүлэх эрх олгогдоогүй байна.

Жишээлбэл, аймгийн ИТХТ-ийн тогтоолоор “Аймгийн Орон нутгийн өмчит байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам” баталжээ гэж үзье. Энэхүү журам нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах зорилготой бөгөөд ЗЗНДНТУТХ-ийн 20.1.7 болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1, 31.3 дахь заалтыг тус тус үндэслэсэн байна. Тэгвэл ЗЗНДНТУТХ-ийн 20.1.7-д хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх заалтыг үндэслэн Захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх тусгайлан олгогдоогүй байна.

¹ 2019.11.14-ний өдөр баталсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 59.2 дахь хэсэгт “2. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна.” гэж өөрчилсөн бөгөөд 2020.05.25-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэнэ. Тиймээс Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн нутгийн удирдлагын тухай салбар хуулиар ИТХ-аар зөвхөн захиргааны хэм хэмжээний акт батлагдахаар өөрчлөгдөх учиртай.

1.2. ЗАХИРГААНЫ ШИЙДВЭРИЙН ХЭЛБЭР, ТЭДГЭЭРИЙН АДИЛ БА ЯЛГААТАЙ ШИНЖ

ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР		
Захиргааны акт	Захиргааны гэрээ	Захиргааны хэм хэмжээний акт

а. *Захиргааны хэм хэмжээний акт ба Захиргааны акт*

Ялгаатай шинж	
<i>Захиргааны акт</i>	<i>Захиргааны хэм хэмжээний акт</i>
Хэлбэрийн хувьд амаар, бичгээр, цахимаар, техник хэрэгслийн тусламжтайгаар, үйл ажиллагаа /бодит үйлдэл, эс үйлдэл/ байна.	Зөвхөн бичгээр гарна. /Хуулиар нэрлэн заасан захиргааны хэм хэмжээний акт батлах үүргээ хэрэгжүүлээгүй эс үйлдэл хамаарна/
Захиргааны байгууллагаас гаргана.	Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас гаргана. Захиргааны байгууллагаас гарах нь ижил боловч захиргааны хэм хэмжээний актын тухайд заавал хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага байх нэмэлт нөхцөлтэй.
Тодорхой тохиолдлыг зохицуулна.	Байнга давтагдах харилцааг зохицуулна.
Боловсруулах, батлахаас өмнө урьдчилж хянуулах, улсын хэмжээнд нэгдсэн бүртгэлд бүртгэх зохицуулалтгүй.	Боловсруулах, батлахаас өмнө урьдчилж хянуулах, улсын хэмжээнд нэгдсэн бүртгэлд бүртгэх зохицуулалттай.
Захиргааны актыг хаяглагдсан этгээд болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд хуульд заасан журмын мэдэгдснээр хүчин төгөлдөр болно.	Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.

Гомдол, нэхэмжлэл гаргахад 30 хоногийн хөөн хэлэлцэх хугацаа үйлчилнэ.	Нэхэмжлэл гаргахад хөөн хэлэлцэх хугацаа байхгүй.
Адил шинж	
Нийтийн эрх зүйн хүрээнд гарна. ЗЕХ-ийн 1 дүгээр зүйлд зааснаар энэ хуулиар захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдтэй харилцах нийтийн эрх зүйн харилцааг зохицуулна. Захиргааны байгууллага нь нийтийн эрх зүйн этгээд болдог тул нийтийн эрх зүйн байгууллагаас гадагш чиглэсэн шийдвэр нь хуулиар олгосон тодорхой чиг үүрэг, эрх хэмжээний хүрээнд нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа хийдэгтэй холбоотой юм.	
Эрх зүйн үр дагавар бий болгоно. Энэ нь иргэн, хуулийн этгээдэд ямар нэг эрх зүйн үр дагаварыг үүсгэнэ. Харилцааны үр дүнд нэгэнт захиргааны байгууллагаас иргэн хуулийн этгээдтэй харилцахдаа хуулиар олгосон чиг үүргийг хэлбэржүүлж байгаа тул эрх зүйн харилцааны нөгөө талын субъект болох эрх зүйн үр дагаврыг үүсгэнэ.	
Гадагш чиглэсэн байна.	
Захирамжилсан шинжтэй байна.	

б. Захиргааны хэм хэмжээний акт ба Захиргааны гэрээний ялгаатай ба адил шинж

Ялгаатай шинж	
Захиргааны гэрээ	Захиргааны хэм хэмжээний акт
Захиргааны байгууллагаас гаргана.	Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас гаргана. захиргааны байгууллагаас гарах нь ижил боловч захиргааны хэм хэмжээний актын тухайд заавал хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага байх нэмэлт нөхцөлтэй.
Тодорхой харилцааг хугацаатай, болзол, нөхцлийг талууд тусгаж зохицуулна. /Гэрээний талууд тодорхой, шууд нэрлэн заасан байна./	Байнга давтагдах харилцааг зохицуулна. /захиргааны хэм хэмжээний актын харилцаанд оролцох этгээдийг бүлгээр, салбар, нутаг дэвсгэрээр тодорхойлдог, шууд нэрлэн заадаггүй./
Маргааны харьяалал нь талуудын сонгосон тохиолдолд арбитр болон эсхүл Захиргааны хэргийн шүүх байх боломжтой.	Маргааны харьяалал нь Захиргааны хэргийн шүүх байна.
Боловсруулах, батлахаас өмнө урьдчилж хянуулах, улсын хэмжээнд нэгдсэн бүртгэлд бүртгэх зохицуулалтгүй. Захиргааны байгууллага гадаад улсын ижил төрлийн захиргааны байгууллага, хуулийн этгээдтэй байгуулах байгууллага хоорондын гэрээний төсөлд тухайн асуудлыг хариуцсан дээд шатны захиргааны байгууллага болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авна.	Боловсруулах, батлахаас өмнө урьдчилж хянуулах, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх зохицуулалттай.
Захиргааны гэрээнд ЗЕХ-д зааснаас гадна Иргэний хуульд заасан гэрээний суурь зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.	Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.
Адил шинж	
Зөвхөн бичгээр гарна.	
Нийтийн эрх зүйн хүрээнд гарна.	
Эрх зүйн үр дагавар бий болгоно.	
Гадагш чиглэсэн байна.	
Захирамжилсан шинжтэй байна.	

Хоёр. ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ

Захиргааны хэм хэмжээний актыг боловсруулах үе шат дараах дараалалтай байна. Үүнд:



Захиргааны хэм хэмжээний актыг боловсруулж, батлах үе шатыг авч үзвэл **бэлтгэх, хянан бүртгэх, хүчин төгөлдөр болох** гэсэн үндсэн гурван үе шатнаас бүрдэж байна.



2.1. БЭЛТГЭЛ ҮЕ ШАТ

2.1.1. Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх /ЗЕХ 61/

Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх ажиллагааг тухайн актыг гаргах эрх бүхий захиргааны байгууллага зохион байгуулна.

ИТХ-аас батлах захиргааны хэм хэмжээний актын төслийн хувьд асуудал оруулах нэгж нь бэлтгэх, эсхүл ЗЗНДНТУТХ-ийн 33.1.7-д заасны дагуу Засаг даргын Тамгын газар /хуулийн хэлтэс/-аар бэлтгүүлэх боломжтой. Захиргааны хэм хэмжээний актаар зохицуулах харилцаа нь бусад захиргааны байгууллагын чиг үүрэгт давхар хамаарч байгаа бол тухайн захиргааны байгууллагаас албан ёсоор санал авна.

***Жишээлбэл,** Олон нийтийн цагдаагийн зөвлөлийн ажиллах журмын төсөл бэлтгэж байгаа бол урамшуулалтай холбоотой асуудлыг санхүү хариуцсан нэгж буюу ажилтан, цагдаагийн хэлтэс буюу төлөөлөгчөөс заавал саналыг нь авах шаардлагатай болно. Хэрэв энэхүү журмын дагуу чиг үүрэгт хамаарах байгууллагын саналыг нь захиргааны хэм хэмжээний актын төсөлдөө хүлээж аваагүй бол, түүнийхээ үндэслэлийг тайлбарлан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад захиргааны хэм хэмжээний актыг хянуулж, бүртгүүлэхдээ уг тайлбарыг хамт хүргүүлнэ.*

Төсөл боловсруулах үе шатанд:

- Ажлын хэсэг байгуулах
- Тооцоо, судалгаа хийх
- Эх сурвалж судлах
- Төсөл бичих зэрэг ажил хийгдэнэ.

2.1.2. Захиргааны хэм хэмжээний актад нөлөөллийн шинжилгээ хийх /ЗЕХ 61/:

Шийдвэрийн төслийг боловсруулахдаа тухайн захиргааны хэм хэмжээний актын эдийн засаг, нийгмийн амьдралд үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан судалж, тооцооллыг нөлөөллийн шинжилгээний хамт бэлэн болгосон байна.



ХЗДХ-ийн сайдын 2018.07.25-ны өдрийн А/147 дугаар тушаалаар “Нөлөөллийн шинжилгээг хийх аргачлал”-ыг баталсан:

- акт гаргах үндэслэл, шаардлага, зорилт;
- тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;
- акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлгийг тодорхойлох;
- хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх;
- тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх;
- актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо.

Дээрх зургаан нөхцлөөс гадна захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргаснаар иргэн, хуулийн этгээд шууд хэрэгжүүлэх, дагаж мөрдөх бодит нөхцөл байгаа эсэх, сургалт, сурталчилгаа явуулах эсэх зэргийг урьдчилсан судалгаа, тооцоонд тулгуурлан шийдвэрлэх нь чухал үр нөлөөтэй байх ба бусад асуудлыг нөлөөллийн шинжилгээнд хамааруулж болно.

Нөлөөллийн шинжилгээний бүтэц, загвар

/31-р хуудасны захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад хийх Нөлөөллийн шинжилгээний жишээг үзнэ үү./

Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилт;

Энэ хүрээнд захиргааны хэм хэмжээний акт гаргах хууль зүйн үндэслэл, практик шаардлага, бодит нөхцөл байдал, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэснээр гарах үр дүн, зорилгодоо хүрэх эсэхийг тодорхойлно.

ЗЕХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт заасны дагуу хуулиар тусгайлан эрх олгогдсон байх нь акт гаргах хууль зүйн үндэслэл болно.

тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;	Энэ хэсэгт захиргааны хэм хэмжээний акт нь ерөнхий бүтцийн хувьд хэдэн бүлэг, хэдэн зүйлтэй байхыг заахаас гадна актаар ямар харилцааг зохицуулахыг тогтоож, үйлчлэх хүрээг тодорхой тусгана.
акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлгийг тодорхойлох;	Тухайн захиргааны хэм хэмжээний актын улмаас нийгмийн ямар бүлэг, иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгааг тодорхойлж, ЗЕХ-ийн 62 дугаар зүйлд заасан журмын дагуу холбогдох ажиллагааг явуулна.
хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх;	• Ялгаварлан гадуурхсан эсхүл аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх; • Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулж байгаа эсэх, хэрэв тийм бол хуульд нийцсэн эсэх; • Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх; • Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх; • Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдөл бий болох эсэх; • Аль нэг аж ахуйн нэгжид, ялангуяа зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэл бий болох эсэх; • Төрийн байгууллага болон бусад иргэн, хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болох эсэх; • Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эсэх; • Эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд ямар нэгэн саад хориг тогтоох эсэх, хэрэв тийм бол тэр нь хуульд нийцсэн эсэх; • Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх; • Хүнд суртал, авлига гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт байгаа эсэх, байгаа бол тэр нь хуульд нийцсэн эсэх;


тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх;	Тухайн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн актыг орхигдуулалгүй нарийвчлан судалж, эрх зүйн зохицуулалтын давхардал хийдэл, зөрчил үүсгэхээс сэргийлэх арга хэмжээг авах.
актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо.	Тухайн захиргааны хэм хэмжээний актыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцон гаргах. Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх, захиргааны шинэ чиг үүрэг бий болгох шаардлага тавигдах эсэх, тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэх, эсхүл буурах эсэхийг судалж тогтоох.

Нөлөөллийн шинжилгээ хийхэд анхаарах асуудал:
/ХЗДХЯ-ны мэргэжилтний өгсөн зөвлөмж/



- Нөлөөллийн шинжилгээг ЗЕХ-ийн зорилгод бүрэн нийцүүлж боловсруулаагүй, зөвхөн тодорхой бүрдлийг хангуулаад хэм хэмжээний актаа бүртгүүлэх зорилго илүү давамгайлж байгааг анхаарах;
- Аргачлалд заасан асуултад зохих ёсоор бүрэн гүйцэд хариулахгүй, тодорхой бус хариулах, гол судлах шаардлагатай асуудлыг судлаагүй, арга хэмжээ авсан тухайгаа хэлбэрийн төдий дурдах, тооцоо судалгааг хийгээгүй, эсхүл тухайн актын зохицуулалтыг хуулбарлах байдлаар "тийм", "үгүй" гэж хариулах байдлаар хийсээр байгааг засч, бүтээлч болгох. Тухайлбал: Нөлөөллийн шинжилгээний 2.1.3-т "акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлгийг тодорхойлох" гэсэн асуултад "эрх ашиг хөндөгдөх бүлэг байхгүй" гэж бичиж байгааг анхаарах,
- Хэлэлцүүлэг зохион байгуулсан талаар нөлөөллийн шинжилгээний тайланд тусгаагүй, хийсэн тохиолдолд холбогдох баримтыг хавсаргаагүй, ирсэн саналыг авсан эсэх талаар мэдээлэл байхгүй;
- Нөлөөллийн шинжилгээний танилцуулгыг шийдвэр гаргах эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд гарч байгааг анхаарч ажиллах.

2.1.3. Санал авах ажиллагаа /ЗЕХ 62.1/



ЗЕХ-иар иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар захиргааны байгууллагад хүлээлгэсэн чухал үүргийн нэг нь захиргааны хэм хэмжээний актын төсөлд иргэдээс заавал санал авах үүрэг юм.

Захиргааны хэм хэмжээний актын төслийг бэлтгэж дууссаны дараа төсөл бэлтгэсэн байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авна. /ЗЕХ 62.1/

Олон нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын төсөлд иргэд, хуулийн этгээд саналаа өгөх бололцоог зайлшгүй хангах үүрэг хүлээнэ. Иймээс эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд /залуучууд, эмэгтэйчүүд, татвар төлөгчид, худалдаа эрхлэгчид, ахмад настан, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, малчин, төрийн бус байгууллага гэх мэт/ хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулж, саналыг авсан байна. Уулзалт, ярилцлага, өдөр тутмын сонин хэвлэлд төслийг нийтлэж санал авах, цахим хуудас, харилцаа холбооны хэрэгслээр санал авах гэх мэт хэлбэрээр хэлэлцүүлгийг хийж болно.


Санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах төрөл

Цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байршуулах


Нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг заавал зохион байгуулах

ЗЕХ-ийн 62.3.1-д заасан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлгийг заавал хийхээр 62.2-т хуульчилсан. Харин 62.3.2-62.3.4-т заасан бүлгийн нэмэлт хэлэлцүүлэг хийх эсэхийг ИТХ өөрийн бодит боломжийн хүрээндээ шийдвэрлэж болно.

Тухайлбал, сумын ИТХ-аас “Таримал ургамлыг малаас хамгаалах тухай журам” батлахаар бэлтгэж байгаа бол мал бүхий иргэдийн дунд хэлэлцүүлгийг заавал зохион байгуулна. Харин энэ чиглэлийн эрдэмтэн, судлаач, сумын нийт иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг хийж болно.



Хэлэлцүүлгийн хэлбэр



Хэлэлцүүлэг зохион байгуулахад оролцоог хангах, зорилгодоо хүрэхийн тулд аль болох боломжийн хугацааны өмнө хүртээмжтэй мэдээлэл түгээх нь чухал юм. Нийтийн ашиг сонирхолд хамаарах захиргааны хэм хэмжээний актын асуудлаар нийтэд хүргэхээр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбар, вэб хуудас, олон хүн үзэх боломжтой худалдааны төв, ундны усны худгийн цэг г.м газар байршуулах, баг, хороогоор дамжуулан зарлах, харин хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх бүлэгт хамаарах захиргааны хэм хэмжээний актын асуудлаар тухайн бүлэгтээ хамгийн хүртээмжтэй арга замаар хэлэлцүүлгийн тухай мэдээлэл түгээвэл оролцоо хангасан, үр дүнтэй хэлэлцүүлэг болж чадна.

Хэлэлцүүлгийн мэдээлэл бэлтгэх /ЗЕХ 62/



Захиргааны хэм хэмжээний акт бэлтгэж буй захиргааны байгууллага зохион байгуулсан бүх хэлэлцүүлгийн явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг захиргааны хэм хэмжээний актын төсөлд хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэнэ.

Санал авахгүй байх:

Нэн яаралтай гаргах үндсэн нөхцөл: нийтэд, иргэдэд аюултай нөхцөл байдал бий болсон, аюул нүүрлэсэн, аюулыг нэн даруй зогсоох, урьдчилан сэргийлэх үйлдэл хийх шаардлага зайлшгүй тулгарсан байхыг ойлгоно.


Хойшлуулшгүй тохиолдол: тухайн үүссэн нөхцөл байдлын улмаас захиргааны шийдвэр нэн даруй гаргахгүй бол нийтийн ашиг сонирхол, хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд ноцтой хохирол учирч болзошгүй тохиолдлыг хэлнэ.

Захиргааны хэм хэмжээний актыг нэн даруй батлах шаардлагатай хойшлуулшгүй тохиолдолд ЗЕХ-ийн 62 дугаар зүйлд заасан санал авах ажиллагааг хийхийг шаардахгүй.

/ЗЕХ 63.1/

Хожим тухайн захиргааны хэм хэмжээний акт хууль ёсны эсэхтэй холбоотой маргаан гарвал уг захиргааны байгууллага нэн даруй батлах шаардлагатай эсхүл хойшлуулшгүй тохиолдол байсан болохыг нотлох шаардлагатай болно.

2.1.4. Баталж хүргүүлэх /ЗЕХ 64.1/



Төслийг эцэслэн боловсруулах:

Захиргааны хэм хэмжээний актын төслийг нөлөөллийн шинжилгээний танилцуулга болон хэлэлцүүлгийн мэдээллийн хамт хууль зүйн асуудал хариуцсан нэгж /газар, хэлтэс/, мэргэжилтнээр хянуулна. /ЗЕХ 62.6/ Энэ нь захиргааны байгууллага дотоодын хяналтыг хэрэгжүүлэх зохицуулалт юм.

Аймаг, нийслэлийн ИТХ-ын тухайд тухайн шатны Засаг даргын Тамгын газрын хуулийн хэлтсээр хянуулна. Сум, дүүргийн тухайд эрх зүйн ажилтан байдаг бол түүгээр хянуулах, байдаггүй бол Засаг даргын Тамгын газрын даргаар хянуулах боломжтой. Ингэхдээ нөлөөллийн шинжилгээ болон хэлэлцүүлэг хуульд заасан шаардлага, нөхцөл, журмын дагуу явагдсан эсэх, актын төсөл болон танилцуулга нь хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаана.

Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэсэн байгууллага, албан тушаалтан нь актын төслийг хуралдаанаар хэлэлцэхээс нь өмнө ИТХ-ын ажлын албанд /цаасаар болон файлаар/, нөлөөллийн шинжилгээ хийсэн баримт, хэлэлцүүлгийн танилцуулга, тооцоо, судалгаа, бусад холбогдох материал /хэлэлцүүлгийн тэмдэглэл, оролцсон хүмүүсийн бүртгэл г.м/-ыг хүлээлгэн өгсөн байна.

Төслийг батлах:

Захиргааны
хэм хэмжээний
актыг **хуулиар
тусгайлан эрх
олгогдсон**
захиргааны
байгууллага
батална.



Хууль зүйн асуудал хариуцсан нэгж /газар, хэлтэс/, мэргэжилтнээр захиргааны хэм хэмжээний актын төслийг хянуулсаны дараа түүнийг баталж, хүргүүлнэ. Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон тухайн шатны ИТХ батална. Ийнхүү баталснаар захиргааны хэм хэмжээний актыг хүчин төгөлдөр гэж үзэхгүй бөгөөд түүнийг хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлэхэд бэлэн болсныг илэрхийлнэ.

“Хуулиар олгогдсон тусгайлсан эрх” болох эсэхийг тогтоохын тулд ИТХ ба ИТХ-ын Тэргүүлэгчдийн эрх хэмжээг ялгамжтай авч үзэх шаардлагатай.

ЗЗНДНТУ–т Хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчид энэ хуулийн 18.1.1.“е”, 18.1.1.“ж”, 18.1.2.“г”, 18.1.2.“ж”, 18.1.2.“з”, 18.1.3.“в”, 18.1.3.“г”, 18.1.3.“ж”, 18.1.3.“з”, 18.1.3.“к”, 18.1.3.“л”, 18.1.3.“н”-д заасан Хурлын бүрэн эрхийг Хуралд дараа тайлагнахаар Хурлын чөлөө цагт хэрэгжүүлж болохоос гадна дараахь асуудлыг өөрийн бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ:....

2.2. ХЯНАН БҮРТГЭХ ҮЕ ШАТ



Захиргааны хэм хэмжээний актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, бүртгэнэ. /ЗЕХ 64.3/

Захиргааны хэм хэмжээний актыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ. /ЗЕХ 64.4/

ИТХ-аас баталсан захиргааны хэм хэмжээний актыг ХЗДХЯ хүлээн аваад хууль зүйн шаардлагыг хянаж, улмаар улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ. ХЗДХЯ-наас ЗЕХ-д заасан захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагыг хангасан эсэх, нөлөөллийн шинжилгээг зохих аргачлалын дагуу хийсэн эсэх, санал авах хэлэлцүүлгийг хийж саналыг тусгасан эсэх зэргийг хянасны үндсэн дээр бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ. Хэрэв ХЗДХЯ хуулийн шаардлагыг хангаагүй гэж үзвэл тухайн захиргааны хэм хэмжээний актыг бүртгэхээс татгалзах үндэслэл болох бөгөөд баталсан ИТХ-д буцаан хүргүүлнэ. /ЗЕХ-ийн 65.1, 65.2/

ИТХ-аас захиргааны хэм хэмжээний актыг хянуулж, бүртгүүлэхдээ дараах баримт бичгийн бүрдлийг хангасан байна: /ЗЕХ 66.1/


ИТХ дангаараа баталсан бол:

- Захиргааны хэм хэмжээний акт гурван хувь:
 - албан ёсны эх хувь
 - түүний баталгаажуулсан хуулбар хоёр хувь
- цахим хувилбар
- нөлөөллийн шинжилгээний танилцуулга
- хэлэлцүүлгийн талаарх мэдээлэл

Хуулиар эрх олгогдсон бусад захиргааны байгууллагатай хамтран баталсан бол:

Тухайн актад нэр нь эхэлж бичигдсэн захиргааны байгууллага хариуцан хуулийн 66.1.1-д заасан баримт бичгээс гадна хамтран баталсан бусад байгууллагын тоогоор тухайн актыг баталгаажуулсан хуулбар.

2.2.1. Захиргааны хэм хэмжээний актыг хянан бүртгэх /ЗЕХ 66.3/



Захиргааны хэм хэмжээний акт хуульд заасан шаардлагыг хангаагүй гэж ХЗДХЯ дүгнэлт гаргасан бол:



ХЗДХЯ-наас захиргааны хэм хэмжээний актыг бүртгэсэн тохиолдолд актын хувиуд дээр бүртгэлийн тэмдэглэгээ хийн албан ёсны хувийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд, баталгаажсан хуулбарын нэг хувийг батласан байгууллага руу, үлдсэн нэг баталгаажсан хуулбар хувийг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д хэвлүүлэхээр тус тус хүргүүлдэг.

Нөлөөллийн шинжилгээний танилцуулга, хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг захиргааны хэм хэмжээний актыг хянахад ашиглаж, дараа нь бүртгэгдсэн захиргааны хэм хэмжээний актын хамт улсын нэгдсэн санд хадгална.

2.3. ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ:

Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлүүлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

Монгол Улсын Үндсэн хуулийн 26.3-т “Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно” гэж заасны дагуу хууль нь “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлснээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болдог.

Үүнтэй адил, улсын хэмжээнд, тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд хуулийн адил үйлчилдэг захиргааны хэм хэмжээний актыг бүрэн эхээр нь уншиж танилцах, мэдэхгүйгээр иргэн, хуулийн этгээд, байгууллагаас түүнийг дагаж мөрдөх боломжгүй юм. Иймээс захиргааны хэм хэмжээний актыг бүртгэснээс хойш 10 өдрийн дотор “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д бүрэн эхээр нь нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.



Хэрэв хүчин төгөлдөр бус захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдүүлбэл үүсэх үр дагаврыг захиргааны хэм хэмжээний акт гаргасан хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага хариуцна.

Хүчин төгөлдөр бус буюу захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд хэвлэгдээгүй захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэхийг иргэн, хуулийн этгээдээс шаардаж болохгүй бөгөөд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн хариуцлага хүлээлгэхгүй.

Захиргааны хэм хэмжээний актыг цахим хуудаст нийтлэх:

ХЗДХЯам

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан
www.legalinfo.mn


- ✓ Бүрэн эхээр нь нийтлэнэ.
- ✓ Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн он, сар, дугаарыг заана.

ИТХ

Өөрийн албан ёсны цахим хуудас
www.khural.mn

3.1. ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ:

3.1.1. Нэмэлт өөрчлөлт оруулах



3.1.2. Нэмэлт өөрчлөлт болон хүчингүй болгосныг бүртгэх

Захиргааны хэм хэмжээний актад нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болсонд тооцсон тохиолдолд уг шийдвэрийг ЗЕХ-ийн 65 дугаар зүйлд заасан журмын дагуу хянан улсын нэгдсэн бүртгэлд хөдөлгөөн хийж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэнэ.


Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн зөрчилтэйн улмаас ЗЕХ-д заасан журмын дагуу хүчингүй болсон бол уг захиргааны хэм хэмжээний актыг баталсан ИТХ энэ тухай албан бичгийг хүчингүй болгосон актын хуулбарын хамт ХЗДХЯ-нд ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

3.2. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ЗЕХ-ийн 69.1-ийн дагуу Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актад жил бүр **хяналт-шинжилгээ, үнэлгээ** хийж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг цаашид авах арга хэмжээний талаарх саналын хамт ХЗДХЯ-нд хүргүүлнэ.

Хяналт шинжилгээ, үнэлгээ нь аливаа эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн талаархи холбогдох бүх мэдээллийг системтэйгээр цуглуулан, дүн шинжилгээ хийж тухайн зохицуулалт үр нөлөөтэй байгаа эсэх, зорилгоо хангаж байгаа эсэх, хэрэгжилт нь хангалттай байгаа эсэхийг тогтооно. Ингэснээр тооцоолоогүй эерэг, сөрөг үр нөлөө, үр дагавар хэнд үүсч, тухайн харилцааг үр дүнтэй зохицуулж чадаж байгаа эсэхийг хэмжих боломжтой болох юм.

Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнд захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр гаргах, зарим тохиолдолд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ч гаргах боломжтой.



